



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 01/185

Улаанбаатар хот

Болзолт уралдаан зарлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн Засгийн газрын 2016 оны 159, 222 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2016 оны 02 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, улаанбурхан-улаанууд өвчний эсрэг вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг зохион байгуулж байгаатай уялдуудан хамралтыг сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбурхан-улаанууд өвчний эсрэг вакцины нэмэлт дархлаажуулалтын хамралтыг сайжруулах болзолт уралдааныг 5 дугаар сарын 12-ноос 14 хоногийн хугацаатай зарласугай.

2. Улаанбурхан-улаанууд өвчний эсрэг вакцины нэмэлт дархлаажуулалтын хамралтыг сайжруулах болзолт уралдааны шалгуур үзүүлэлт, дүгнэх, урамшуулах журмыг нэгдүгээр, уралдааны ажлыг зохион байгуулалтаар хангах, дүгнэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Улаанбурхан-улаанууд өвчний эсрэг вакцины нэмэлт дархлаажуулалтын чанарын өндөр түвшинд зохион байгуулж, зорилтот бүлгийн хүн амыг бүрэн хамруулж, хийсэн ажлын тайлангаа 5 дугаар сарын 28-ны дотор ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт үүрэг болгосугай.

4. Болзолт уралдаанд шаардагдах 15 (арван таван) сая төгрөгийг холбогдох арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (Т.Баярсайхан)-т, болзолт уралдааныг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үр дүнг нэгтгэн 5 дугаар сарын 30-ны дотор шалгаруулахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (С.Энхболд)-т, болзолт уралдааны явцад хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Оюунчимэг)-т тус тус үүрэг болгосугай.


САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080659

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 05 сарын 28 өдрийн
118 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



**УЛААН БУРХАН-УЛААНУУД ӨВЧНИЙ ЭСРЭГ ВАКЦИНЫ НЭМЭЛТ
ДАРХЛААЖУУЛАЛТЫН ХАМРАЛТЫГ САЙЖРУУЛАХ БОЛЗОЛТ УРАЛДААНЫ
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ДҮГНЭХ, УРАМШУУЛАХ ЖУРАМ**

Зорилго

Засгийн газрын 2016 оны 159, 222 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2016 оны 02 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, улаанбурхан-улаанууд өвчний эсрэг вакцины нэмэлт дархлаажуулалтын хамралтыг сайжруулах

Хамрах хүрээ

- Өрхийн эрүүл мэндийн төв
- Сумын эрүүл мэндийн төв
- Дүүргийн Эрүүл мэндийн төвийн Дархлаажуулалтын нэгж

Хугацаа

2016 оны 5 дугаар сарын 12-25-ны өдрүүд

Болзолт уралдааны шалгуур үзүүлэлтүүд:

№	Шалгуур үзүүлэлт	Хамралт	Өгөх оноо	Аргачлал
1	18-30 насны дархлаажуулалтад хамрагдсан хүний тоо	Хамрагдвал зохих хүний тоо		Тайлан, ХӨСҮТөвийн мэдээнээс
2	Дархлаажуулалтын хамралтын хувь			Тайлан, ХӨСҮТөвийн мэдээнээс
3	Ажилгүй болон хүрч үйлчлэхэд хүндрэлтэй иргэдийг вакцинд хамруулах хуваарь гаргаж, хуваарийн дагуу дархлаажуулалтад бүрэн хамруулсан байна			Тайлан, ХӨСҮТөвийн мэдээнээс
4	Дархлаажуулалтын үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулсан байдал			Тайлангаас

5	Дархлаажуулалтын үйл ажиллагааг нэмэлт санхүүжилтээр дэмжсэн байдал			Захирамж болон тайлангаас
6	Дархлаажуулалтын явцад мэдээлэл, сурталчилгааны материал тараасан, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байдал			Тайлангаас
7	2016 оны эхний 4 сарын байдлаар улаанбурхан өвчнөөр өвчилсөн хүний тоо			ЭМХТөвийн мэдээнээс
8	Улаанбурхан өвчний эмчилгээнд хамрагдсан хүний тоо, эдгэрэлтийн хувь			ЭМХТөвийн мэдээ
9	Улаанбурхан өвчний улмаас нас барсан тохиолдлын хувь			ЭМХТөвийн мэдээ

Болзолт уралдааны материал хүлээн авах, дүгнэх

1. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар хэрэгжүүлсэн ажлын тайлангаа 2016 оны 5 дугаар сарын 28-ны дотор ЭМСЯ-ны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлнэ.

2. Эрүүл мэнд спортын яамны үнэлгээний ажлын хэсэг нь аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газруудаас ирүүлсэн тайлантай танилцаж, үнэлгээ өгнө.

3. Эрүүл мэнд спортын яамны удирдлагад танилцуулж, шийдвэрлүүлнэ.

4. Болзолт уралдааны удирдамжид тусгасан үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн Эрүүл мэндийн төвийн Дархлаажуулалтын нэгж, өрх, сумын эрүүл мэндийн төвийг шагнаж, урамшуулна.

5. Болзолт уралдаанд амжилттай оролцсон байгууллагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 05 сарын 18 өдрийн
1125 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт



УРАЛДААНЫ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАЛТААР ХАНГАХ, ДҮГНЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн ахлагч: Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- Нарийн бичиг: Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Шуурхай удирдлагын албаны дарга
- Гишүүд: Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга
Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга
Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
Төрийн захиргааны удирдлагын газрын хуулийн албаны дарга
ХӨСҮТ-ийн Тандалт сэргийлэлт хариуцсан дэд захирал
ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албаны дарга

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 05 сарын 11 өдрийн
А/105 дугаар тушаалын 3 дугаар
хавсралт



БОЛЗОЛТ УРАЛДААНЫ ШАГНАЛЫН ХЭМЖЭЭ

№	Шагнах байгууллагын нэрс	Шалгаруулах тоо	Шагналын хэмжээ(сая/төг)
1	Шилдэг сумын эрүүл мэндийн төв	1	3 сая/төг
2	Шилдэг өрхийн эрүүл мэндийн төв эсвэл дүүргийн дархлаажуулалтын нэгж	1	3 сая/төг
3	Тэргүүний өрхийн эрүүл мэндийн төв эсвэл дүүргийн дархлаажуулалтын нэгж	4	Тус бүр 1 сая төгрөг
4	Тэргүүний сумын эрүүл мэндийн төв	4	Тус бүр 1 сая төгрөг
5	Үйл ажиллагааны зардал сурталчилгаа, өргөмжлөл.		1 сая төгрөг
	Дүн	10	15 сая төгрөг